

**1950-ИАД ОНЫ ҮЕИЙН МОНГОЛЫН НИЙГМИЙН УЛС ТӨРИЙН
УХАМСАРЫН ТУХАЙД****А.Жамбал**

ФСЭХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

1950-иад он бол манай орны эдийн засгийн хувьд дэлхийн II дайны уршигаар учирсан аж ахуйн хохирол, сүйтгэлийг 1940-өөд оны хоёрдугаар хагаст үндсэнд нь арилгаж чадсны дагуу эдийн засгийг цааш сэргээж шинэ шатад гаргаж өсгөн хөгжүүлэх болсон; социал хүрээний хувьд эдийн засгийн өсөлтөд тулгуурлаж хүн амын материаллаг амьдралыг сайжруулах, эрүүл мэнд, соёл, боловсролын түвшинг ахиулах болсон; улс төрийн амьдралын хувьд тухайн үед Монгол ба ЗХУ-д тогтон ноёрхож байсан ардчилсан бус, хатуу дэглэмийн удирдагчид болох Х.Чойбалсан 1952 онд, И.В.Сталин 1953 онд нас барсны дараа эдгээр дэглэмд зарим талын эерэг өөрчлөлт гарч “урь орох” болсон бөгөөд түүний нөлөөгөөр нийгэм дэх улс төрийн болон үзэл суртлын хатуу хяналт, дарамт тодорхой хэмжээгээр багасч, тэр нь хүмүүсийн үзэл ухамсар, ялангуяа сэхээтэн, тэр дотор нийгэм-хүмүүнлэгийн салбарын сэхээтэн мэргэжилтнүүдийн оюун санаа, сэтгэхүйн хүлээс, айдас болгоомжлол багасахад нөлөөлжээ.

Монголын нийгмийн амьдралд ЗХУ-ын нам, төрийн бодлого, түүний өөрчлөлт, үйл явдлууд асар их нөлөө оролцоотой байсан билээ. ЗХУКН-ын 1956 онд хуралдсан түүхэн XX их хурлаас ЗХУ-д тогтон ноёрхсон сталинист тоталитар дэглэмийн гэмт үйл ажиллагааг “нэг хүнийг, тухайлбал Сталиныг тахин шүтсэн явдал ба түүний үр дагавар” гэсэн томъёоллоор хурц шүүмжлэн буруушааж, хор уршгийг нь арилгах, цаашид гаргахгүй байх, хамтын удирдлагын зарчмыг хангах, ардчиллыг бэхжүүлэх талаар чухал шийдвэр, заалт гаргасан нь (1) тухайн үедээ сталинизмд өгсөн улс төр, үзэл суртлын том цохилт болжээ. XX их хурлын эл шийдвэр, үзэл санааны чиг шугам ЗХУКН-ын Төв Хорооны 1957 оны 6 дугаар сард хуралдсан Бүгд хурал, XXI (1959 он), XXII их хурлаар (1962 он) дамжиж Н.С.Хрущевыг 1964 оны 10 дугаар сард нам, засгийн газрын тэргүүнээс буулгах хүртэл үргэлжилсэн байна. Түүний үр дүнд өмнө нь сталинизмын хүйтэн жаварт хайруулан жиндсэн зөвлөлтийн нийгэм бүлээрсэн уур амьсгал манай оронд нэвтрэн орж, МАХН-ын үйл ажиллагаанд ихээхэн нөлөөлжээ.

МАХН-ын Төв Хорооны 1956 оны дөрөвдүгээр сард хуралдсан IV Бүгд хурлаар “ЗХУКН-ын XX их хурлын дүн ба манай намын зорилтын тухай” Улс төрийн Товчооны илтгэлийг хэлэлцэж гаргасан тогтоолд нийгмийн улс төрийн амьдрал, намын онолын сэтгэлгээ, үзэл суртлын ажлын талаар заахдаа нам, олон түмний ролийг бууруулж, ганц хүнийг тахиж шүтэхийн илрэл бүртэй хатуу тэмцэх, хамтын удирдлагыг нам, улс, олон нийтийн байгууллагын ажилд гүнзгий нэвтрүүлэх, нэг хүнийг тахиж бишрэхийн уршгаар хувьсгалт хуулийг зөрчих, улсын зарим байгууллагыг намын хяналтаас гаргахад хүрч байсныг Улс Төрийн Товчоо нарийвчлан хянаж шалгах, намын олон түмний идэвхийг өрнүүлэхийн тулд шүүмжлэл, өөрийн шүүмжлэлийг аль болохоор нээх, шүүмжлэлийг хавчин шахах

явдалтай эвлэрэшгүй тэмцэх, намын үзэл суртлын ажлыг хангах, социалист байгуулалтын явцаар гарч буй үзэл суртлын чухал асуудлыг боловсруулах, суртал ухуулгын ажлыг амьдралтай холбох, нам, улсын бүх удирдах ажилтан нар өөрсдийн биеэр хөдөлмөрчдийн өмнө лекц, яриа байнга хийх, амьдралыг гүн судлахыг чухал зорилт болгож заасан байна (2,296).

Сталинист байр суурь, үзэлтэй Маленков, Каганович, Молотов нарыг намын эсрэг бүлэглэсэн үйлдлээр нь буруушааж нам, засгийн газрын удирдлагаас гаргасан ЗХУКН-ын Төв Хорооны 1957 оны 6 дугаар сарын Бүгд хурал, мөн ХХ их хурлын чиг шугамыг үргэлжлүүлэн баримтласан ХХI их хурлын дүнгээс МАХН өөрийн улс төр, үзэл суртлын үйл ажиллагаандаа дүгнэлт хийсэн чухал тогтоолуудыг Намын Төв Хорооны VI бүгд хурал (1957.7 сар), III Бүгд хурлаас (1959.3 сар) тус тус гаргажээ (3).

1950-иад оны үеийн эдгээр болон бусад шинэлэг, эерэг үйл явдал, өөрчлөлт нь олон нийт, сэхээтэн, албан хаагчдын үзэл ухамсар, сэтгэл зүйд идэвхжүүлэх нөлөө үзүүлж, тэд улс орны түүхэн замнал, хөгжлийн түвшин, оршин буй бэрхшээл, алдаа дутагдал, шийдвэрлэвэл зохих чухал зорилтуудын талаархи санал бодлоо шүүмжлэлт сэтгэлгээгээр илэрхийлэх болсон байна. Гэвч дээр дурдсан улс төр, үзэл суртлын нааштай, шинэлэг арга хэмжээ, өөрчлөлт нь ЗХУ-д ч, манай оронд ч ардчилсан бус дэглэмийн хүрээнд хийгдсэн хэсэгчилсэн алхмууд байсан бөгөөд тууштай, язгуур чанартай биш, тиймээс ч нийгмийг бүхэлд нь ардчилж чадах хүч нөөцтэй байсангүй. Ардчилсан бус, хуучин дэглэм өөрийн нь хүрээн дотор үүсэн гарч эхэлсэн шинэ дэвшилт үзэгдэл, шүүмжлэлт үзэл санааг “сэхээтний төөрөгдөл”, “намын бодлогод харш үзэл санаа, үг, өгүүлэл” хэмээн нэрлэж буруушаан дарсан билээ (4).

1950-иад оны үеийн монголын философи, улс төрийн сэтгэлгээний ерөнхий төлөв байдлыг хөндөхдөө тэр цагийн намын онолын сэтгэлгээ, үзэл суртлын үйл ажиллагааны байдлын талаар заавал өгүүлэх хэрэгтэй болно. Үүнд тодорхой учир шалтгаан байгаа билээ. Философийн ухаан ардчилсан бус нийгэмд эрх баригч намын онолын баримтлал, үзэл суртлаас хараат, тиймээс чөлөөт, шүүмжлэлт чанартай байж чадахгүй. Энэ нь түүний хөгжилд гол саад болдог. Тэгэхдээ эрх барьсан нам философи сэтгэлгээг өөрийн баримталсан онол, үзэл суртлын хүрээ хязгаар дотор харьцангуй чөлөөтэй байлгаж хөгжүүлэх, түүнд тулгуурлах хэрэгтэй болно. Тэгэхгүйгээр намын онолын сэтгэлгээ хөгжихгүй, үзэл суртлын баримтлал нь ул үндэстэй боловсрогдохгүй, үүнээс улбаалж нам өмнөө тавьсан зорилго, үүргээ биелүүлж чадахгүйд хүрдэг байна. Энэ бол хамгийн наандаж ХХ зууны хоёрдугаар хагаст социализмын замаар замнасан орнуудын оюун санааны амьдрал, туршлагаас тод харагдсан зөрчилт, ээдрээтэй үзэгдэл билээ. Ийм байдал 1950-иад он, ер нь 1990 он хүртлэх үеийн монголын нийгмийн оюун санааны амьдрал, түүний дотор философи сэтгэлгээнд мөн адил оршин илэрч байсныг үгүйсгэх аргагүй юм.

Марксист, ялангуяа ленинист сургаал ёсоор социалист нийгэм байгуулах нь эдийн засгийн мөлжлөг, улс төрийн дарангуйлал, оюун санааны боолчлол, бүхэлдээ нийгмийн дарлалаас чөлөөлөгдсөн хөдөлмөрчин олон түмний өөрийн нь бүтээлч үйл хэрэг юм. Тэгэхдээ бүтээн байгуулагч олон түмэн ямар нийгмийг яаж

байгуулахаа мэддэг, ухамсартай, өөрөөр хэлбэл нийгэм-улс төрийн зохих мэдлэгтэй, боловсролтой байх ёстой. Олон түмний чухам тийм чанараар нь социалист нийгэм амьдрах чадвартай, социалист төр хүчтэй байж чадна. Марксист-ленинист сургаалын энэхүү үзэл санааг эл агуулгаар нь буруутгах аргагүй, түүгээр ч үл барам түүний утга санааг ялимгүй хувиргаж ардчилсан, хүмүүнлэг, энэрэнгүй, зах зээлийн зохицуулалттай иргэний нийгэм байгуулах тухай өнөөгийн үзэл баримтлал, практик үйл ажиллагаанд буулгаж баримтлах боломжтой. Ерөөс аль ч нийгэмд хүмүүс, иргэдийн ухамсарт чанар, улс төрийн боловсрол, нийгмийн тухай мэдлэг чухал үүрэг, ач холбогдолтой ажээ. Хэргийн гол учир утга нь эдгээр чанар, чадварыг хүмүүст ямар зорилгоор, ямар арга замаар, яаж бүрдүүлэн төлөвшүүлэх вэ гэдэгт л байгаа болов уу.

Нийгмийн хөгжил, төлөв байдалыг илэрхийлдэг олон үзүүлэлт, шалгуураар монголын нийгэм ХХ зууны эхэн үед үндсэндээ хожуу үеийн дундад зууны төлөв байдалтай байсан бөгөөд МАХН түүнийг 1920-иод оноос хувьсгалт ёсоор, яваандаа социалист арга замаар өөрчлөн шинэтгэх, хөгжүүлж дэвжүүлэх зорилго, бодлого баримтлан хэрэгжүүлэхдээ олон түмнийг ухамсартай, нийгэм-улс төрийн зохих мэдлэг, боловсролтой болгох талаархи марксизмын дээрхи үзэл санааг чухалчилсаар иржээ. Энэхүү олон талтай үйл явц бүхий асуудлыг манай орны түүхч, философич, шашин, соёл судлагч эрдэмтэд өөр өөрийн судалгааны аспектээр авч үзэж нэгэн сэдэвт бүтээлүүдийг нийтлүүлсэн байна (5).

МАХН-ын үзэл суртал, шинжлэх ухаан, боловсрол, соёл гэгээрлийн талаархи тогтоол шийдвэр, баримт бичиг болон судалгааны холбогдох зохиол бүтээлүүдээс үзвэл олон түмэнд улс төрийн мэдлэг, боловсрол олгох олон талтай үйл ажиллагааны гол субъект нь МАХН, түүгээр удирдуулсан МҮЭ, МХЗЭ болон олон нийтийн бусад байгууллага, гол зорилго нь хүмүүст нийгэм-улс төрийн марксист мэдлэг, боловсрол эзэмшүүлэх, ертөнцийг үзэх шинжлэх ухааны үзэл төлөвшүүлэх, үндсэн арга хэлбэр нь намын суртал нэвтрүүлэг, ухуулга, улс төрийн боловсролын дугуйлан, сургууль бүхий систем, түүнчлэн ардын боловсролын бүх шатны сургуульд заах нийгмийн ухааны хичээл, гол хэрэгсэл нь нийгэм-улс төр, онолын сэтгүүл, тогтмол сонин, лекцийн эмхтгэл, нийгмийн ухааны сурах бичиг, гарын авлага, бусад ном зохиол, радио, түүнчлэн үзүүлэн таниулах материал сэлт байжээ.

Намын онолын сэтгэлгээ нь түүний их, бүгд хурлын илтгэл, тогтоол, удирдагчдын бичсэн өгүүлэл зэрэгт голлон тусгалаа олж илэрхийлэгдэж байсан бол намын улс төр, үзэл суртал, гэгээрлийн үйл ажиллагааны зааж чиглүүлэх, шийдвэр гаргах гол хэлбэр нь тогтоол байсаар иржээ. МАХН-аас 1940 -өөд онд намын үзэл суртал, гэгээрэл-хүмүүжлийн олон талтай асуудлаар дагнасан болон тэдгээрийн аль нэг зорилтыг бусад асуудлаар гаргасан тогтоолд чухалчлан зааж оруулсан нийтдээ 40 гаруй тогтоол гарчээ. Анхааран авч үзэхэд 1940-өөд оноос өмнөх болон дараагийн үеийн арав арван жилүүдэд үзэл суртлын талаар ийм олон тогтоол шийдвэр гараагүй байна.

МАХН-ын Х их хурлаас “Манай ард түмний соёл боловсрол дорой ба бичиг үсэг мэдэхгүй байгаа явдал бол манай ард түмнийг эрх жаргалант баяр цэнгэлт аж амьдралд хүргэх замыг хааж буй чулуу мөн болно. ... Улс төрийн мэдрэлийн

өсөлтгүйгээр ард түмний улс төрийн идэвхийн өсөлт байх бололцоогүй болно (6,55). ... Манай намын ажлын сүрхий дутагдалуудын нэг нь намын гишүүдийн улс төрийн боловсрол дорой байгаа явдал мөн” (7,66) гэж дүгнэн тэмдэглээд цаашдаа нам ба түүний удирдлагын үзэл ба улс төрийн ажлын гол зорилго бол намын гишүүдийг Маркс-Лениний суртлаар хүмүүжүүлэх, тэдний улс төрийн онолын мэдрэлийн хэмжээг дээшлүүлэх, ард түмний дотор явуулах нам, улс төрийн таниулгын ажлыг дэлгэрүүлэх, түүнд бүхий л байгууллагуудын хүчийг бөөгнөрүүлэн зохиох явдал болохыг онцлон заажээ (8,350-351).

МАХН 1940-өөд оны дундаас дэлхийн хоёрдугаар дайн зөвлөлтийн ард түмний ялалтаар төгсөж, Монгол Улсын гадаад дотоод нөхцөл байдалд энх тайван, бүтээн байгуулалтын таатай нөхцөл бүрэлдсэн бололцоог бүрэн ашиглаж нийт намын гишүүд, хөдөлмөрчдийн улс төрийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэхийг улам чухалчилах болсон байна. Энэ зорилгоор олон ажил, арга хэмжээ зохиосны нэг нь 1946 оны 10 дугаар сард МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооноос улс төр-онолын “Суртал нэвтрүүлэгч” нэртэй сэтгүүлийг улирал тутамд гаргаж байхаар тогтоол гаргасны дагуу эл сэтгүүл 1947 оноос тогтмол нийтлэгдэж, намын удирдах хүчин, суртал нэвтрүүлэгч, нийт сэхээтний нийгэм-улс төрийн мэдлэг, боловсролд төдийгүй нам болон нийгмийн ухааны чиглэлийн ажилтнуудын онолын сэтгэлгээний өсөлтөд ач тустай индэр болжээ.

Өмнөх 1930-аад оны үед улс орны гадаад дотоод нөхцөл байдал ихээхэн ээдрээтэй, феодалын хөрөнгө хураасан, “зүүний” нугалаа, Халхын голын дайн, улс төрийн хэлмэгдүүлэлт зэрэг доргио донсолгоотой үйл явдлууд тохиолдсон, нам үзэл суртлын асуудлыг зохих хэмжээгээр анхаарч байсан ч гэсэн гол анхаарал, бодлого нь улс орны батлан хамгаалах хүчин чадал, эдийн засаг, улс төр-зохион байгуулалтыг бэхжүүлэхэд голлон чиглэсэн ажээ. Тэгэхдээ МАХН-аас 1940-өөд оны үед үзэл суртлын асуудлаар гаргасан тогтоолууд нь багагүй тохиолдолд онол-үзэл баримтлалын чанар, түвшин дутмаг, аль нэг тодорхой, нэгж бүхий зорилтыг деталчилж, тоочиж заасан, нэлээд тохиолдолд болж өнгөрсөн ямар нэг үйл явдал, нийтлэгдэж гарсан ном бүтээлийг шүүмжлэн буруушаасан агуулгатай байсан нь ажиглагдаж байгаа юм.

1950-иад онд үзэл суртлын асуудлаар 1940-өөд оныхтой харьцуулахад тооны хувьд цөөн, 15 орчим тогтоол шийдвэр гарсан байгаа бөгөөд тэдгээрийн агуулга, үзэл санаа, зорилго чиглэл зэрэг нь онолын үзэл баримтлалын чанартай болж өөрчлөгдөн сайжирч байжээ. Тэдгээр тогтоол нь тухайн үеийн үзэл суртал, гэгээрэл-хүмүүжлийн ажлын бодит байдал, түвшин, түүнд оршиж буй дутагдал, дэвшин тавигдсан зорилт, асуудал болон тэдгээрийг шийдвэрлэх арга замыг тодорхойлон заахын хамт ер нь намын онолын сэтгэлгээ, үзэл суртлын үйл ажиллагааг бүхэлд нь сайжруулж шинэ ахиц, шатад хүргэх үзэл санааг агуулсан, харьцангуй бүтээлч шинжтэй болсон байна.

1950-иад онд нийгмийн улс төрийн ухамсарт бүхэлдээ болон түүний дотор намын онолын сэтгэлгээ, үзэл суртал, хүмүүжлийн ажил, соёл, боловсрол, нийгмийн ухааны салбарт шинэ, өмнөх үеийнхээс илүү өргөн бөгөөд нарийн зорилт үүсэн тавигджээ. Тэр бол нэг талаас МАХН-ын 1954 онд хуралдсан XII их хурлаас тус оронд социализмын үндсийг байгуулах зорилгын хүрээнд үндэсний

соёлыг бүх аргаар хүмүүжүүлэх явдал ээлжит зорилт болж тавигдсан, түүний хэрэгжилтийг намын үзэл суртал, соёл-хүмүүжлийн үйл ажиллагаагаар хангах чухал хэрэгцээ шаардлага тулгаран гарсан, нөгөө талаар түүнийг бодитойгоор хэрэгжүүлэх хүч бололцоо, тодруулж хэлбэл өндөр боловсролтой, мэргэжлийн мэдлэг чадвартай боловсон хүчин нэн дутмаг, урьд нь бэлтгэгдсэн, байгаа мэргэжилтэн бүхий боловсон хүчний мэдлэг, чадвар нь шинэ зорилтын шаардлагыг тэр бүр хангаж чадахгүй байсан ийм хоёр талын зөрчил бүхий нөхцөл байдалтай байв.

1950-иад онд төдийгүй 1960-аад оны эхэн үед ч гэсэн улс ардын аж ахуйн салбаруудад тусгайлан бэлтгэгдсэн мэргэжилтэн боловсон хүчин дутмаг байжээ. 1962 оны нэгэн тоо мэдээгээр тухайн үед бараг бүгдээрээ шахуу ажил албатай, ямар нэгэн хөдөлмөр эрхлэж бусдыг хошуучилж байсан намын нийт гишүүдийн 45 хувь нь бага сургуулийн боловсролгүй, 50 орчим хувь нь бичиг үсэг бага мэддэг байжээ (9).

1950-иад онд дэвшин тавигдсан дээр дурдсан зорилт, түүнийг хэрэгжүүлэх зайлашгүй хэрэгцээ шаардлага ба байгаа бодит бололцоо, хүч нөөцийн хоорондын зөрчлийг захиргаадалтаар шахаж шаардах, эсвэл хоосон уриалж лоозогнох байдлаар шийдвэрлэх аргагүй байсан бөгөөд тэдгээрийг чухам мэргэжлийн түвшинд хэрэгжүүлж чадах шинэ цагийн өндөр боловсролтой мэргэжилтэн боловсон хүчинг бэлтгэн гаргаж ажиллуулах замаар л амжилттай хэрэгжүүлж чадах байв. Эл хэрэгцээ шаардлагаар чухам 1950-иад онд соёл, боловсрол, шинжлэх ухаан, түүний дотор нийгмийн ухааны салбарт тухайн үедээ өндөр боловсролтой мэргэжилтэн боловсон хүчинг дотоод гадаадад сургаж бэлтгэх ажил эрчимжин өргөжсөн нь үр дүнгээ өгөх болжээ.

Энд шинжлэх ухааны салбарын дээд боловсролтой, эрдмийн зэрэгтэй боловсон хүчний талаар ганц нэг тоо баримт дурдахад 1945 онд монголчуудаас Н.Жагварал анх удаа дэд эрдэмтний зэрэг хамгаалсан, Шинжлэх ухааны хүрээлэнд 1948 онд дээд боловсролтой эрдэм шинжилгээний ажилтан 15 хүн ажиллаж байжээ (10,77). Ийм байдал 1950-иад онд өөрчлөгдөж 1958 оны дүн мэдээгээр манайд эрдмийн зэрэгтэй хүний тоо 63 хүрсэн, үүнээс доктор 3, дэд эрдэмтэн 60, эдийн засаг, нийгэм-хүмүүнлэгийн ухааны салбарт доктор 2 (Б.Ринчин, Н.Жагварал), дэд эрдэмтэн 19 (сурган хүмүүжүүлэх ухаан 1, түүх 8, философи 1, хэл бичиг 4, эдийн засаг - 5) байв (11).

1950-иад онд манай оронд орчин үеийн шинжлэх ухаан, тэр дотор нийгмийн шинжлэх ухаан өмнөх үеийнхээсээ ахиж, хөгжлийн шинэ чухал шатад дэвшин орсон байна. Өмнө нь түүх, хэл шинжлэл, уран зохиол судлал голлож байсан нийгмийн шинжлэх ухаанд дифференциаци буюу салбар ухаануудын ялгарал явагдаж философи, философийн түүх, ёс зүй, төр, эрх зүйн ухааны үндэс суурь тавигдаж тэдгээрийн мэргэжилтэн, эрдэмтэн судлагчдыг бэлтгэх болсон байна.

1950-иад онд түүхийн шинжлэх ухаан эрчимтэй хөгжиж, түүний чухал ололт болж 1954 онд монгол-зөвлөлтийн эрдэмтэдийн анхны хамтын том бүтээл болох "БНМАУ-ын түүх" нэгэн боть зохиол нийтлэгдсэн бол 1951 онд Ц.Пунцагноров гуай анхлан нийт арав гаруй хүн 1951-1960 онд ЗХУ-д түүхийн ухааны дэд эрдэмтний зэрэг, монголын анхны мэргэжлийн философич Д.Төмөр-Очир 1953 онд

монголчуудаас мөн анхлан философийн ухааны дэд эрдэмтний зэрэг хамгаалжээ. Ер нь 1950-иад он бол бүхэлдээ монголын философийн ухааны амьдралд түүний ирээдүйн ололт амжилтуудын эх үүсвэрийг тавьсан шинэ чухал үйл явдлууд бүтэж бий болсон “философид ээлтэй” үе байсан гэж хэлж болно.

Тэгэхдээ философийн ухаан манайд өмнөх 1930-40 -өөд оны үед ч гэсэн тухайн үеийн нийгэм, түүний оюун санааны амьдралын хөгжлийн түвшин, бололцоо, шаардлагын хэр хэмжээгээр ахисаар иржээ. Эл асуудлаар хийгдсэн судалгааны гол бүтээлүүдээс үзвэл манайд марксист философийн үндэсийг 1930-аад онд голчлон намын улс төрийн боловсролын бүлгэмд “махбодыг хоёрдуулан зөрчлийг олох ухаан” (диалектик материализм), “түүхт махбодын асуудал” (түүхийн материализм) нэртэйгээр судалж байжээ (12).

1940-өөд онд намын улс төрийн боловсролын нэгдмэл, бүхэл бүтэн систем бүрэлдэн тогтсон (13,46), 1941 онд Нам ба улсын төв сургуулийг Шинэ хүчний дээд сургууль болгож өөрчлөн байгуулсан, 1942 онд МУИС байгуулагдаж, улмаар “...марксист шинжлэх ухаан, намын түүх, улс төр эдийн засгийн ухаан, философийг сайнаар эзэмшиж чаддаг, тэрчлэн эдгээр ухааныг зөвхөн мэдээд зогсохгүй, эрдэм шинжилгээний ажлыг хийдэг ба мөнхүү ухааныг дээд ба дунд сургуулиудад зааж чадах чадвар бэлтгэл бүхий шинэ хүчнийг гаргахын тулд...” (14) 1947 онд Нийгмийн шинжлэх ухааны факультетыг нээсэн, түүнчлэн өмнө нь багш, санхүү, анагаах, хөдөө аж ахуй зэрэг гол мэргэжилүүдээр байгуулагдсан техникумууд 1940-өөд оны хоёрдугаар хагаст бэхжин хөгжиж, тэдгээрт марксизм-ленинизмын үндэсийг бие даасан хичээл болгож заах болсон зэрэг сургалт боловсролын ололт амжилт, цаашдын хэрэгцээ шаардлагаар манай оронд марксист философийг тусгай хичээлийн хэлбэрээр зааж эзэмшүүлэх болсон байна.

Их, дээд сургуулийн хичээл сургалтын энэхүү практик хэрэгцээ шаардлага нь философийн ухаан манай оронд 1940-өөд онд мэдэгдэхүйц ахиц ололтод хүрэхэд нөлөөлж түлхсэн гол хөшүүрэг бүхий хүчин зүйл болжээ. Түүний үр дүнд чухам 1940-өөд оны эхэн үеэс Д.Төмөр-Очир анхлан монголын шинэ цагийн сэхээтнүүдийн бэлтгэж бичсэн философийн лекцүүдийн анхны эмхтгэл бүхий гарын авлага, мөн философийн асуудлын тодорхой сэдвүүдээр бичигдсэн олон тооны статья (өгүүллийг тэр цагт тийнхүү нэрлэж байжээ), бэсрэг товхимол нийтлэгдсэн (15, 110-114), Д.Төмөр-Очир, Ч.Лодойдамба, Самдан, Дүгэрсүрэн зэрэг сэхээтэн их, дээд сургуульд философийн хичээл зааж байжээ (16, 44;17, 16). Дээд боловсролтой мэргэжлийн философич бэлтгэх анхны алхамаар Д.Төмөр-Очир монголчуудаас мөн л эхнийх болж гадаадын их сургуулийн философийн ангид сурахаар 1945 онд Москвагийн их сургуулийн философийн факультетийг зорьжээ.

Эдгээр ололт амжилт нь философийн ухаан манай оронд 1950-иад онд чанарын шинэ шатад гарч хөгжих хөрс суурь болж үр жимсээ өгсөн байна. Эл үед философийн ухааны хөгжилд гарсан гол чиг хандлага бүхий ололт амжилт бол түүнийг их, дээд сургуулиудад тусгай хөтөлбөрөөр бие даасан гол хичээлүүдийн нэг болгож заах, төгсөлтийн улсын шалгалт авч байх (18), намын улс төрийн боловсролын дугуйлан, онолын семинарын хэлбэрээр судлуулах болсон (19);

үүний дагуу их, дээд сургуульд философийн хичээлийг дагнаж заадаг мэргэшсэн багш нар төрөн гарч боловсорсон (20); өөр нэг чухал зүйл бол философийн онол, түүх, монголын нийгэмтэй холбоотой олон талтай асуудал, сэдвүүдээр судалгааны ажил хийгдэж эхэлсэн, холбогдох ном зохиол, эрдэм шинжилгээний болон сурталчилгааны өгүүлэл олноор нийтлэгдсэн (21); философийн ухаанаар эрдмийн зэрэгтэй багш, эрдэм шинжилгээний ажилтанг бэлтгэхээр гадаад орны аспирантурт сургаж эхэлсэн (22), эл үед философиор үндэсний дорвитой сурах бичиг, гарын авлага хараахан гараагүй байсан тул (23) ЗХУ-ын философич эрдэмтэдийн туурвисан диалектик ба түүхийн материализмын сурах бичгүүдийг монгол хэлнээ хөрвүүлж нийтлүүлсэн байна (24).

1950-иад он, ялангуяа түүний хоёрдугаар хагасын үеийн монголын нийгмийн улс төрийн ухамсарын ахицтай, шинэлэг өөрчлөлт, түүний дотор философийн ухааны дээр дурдсан ололтууд Д.Төмөр-Очир гуайн үйл ажиллагаатай нягт холбоотой юм. Энэ бол тусгайлан авч үзвэл зохих бие даасан чухал сэдэв бөгөөд тиймээс энд түүний зөвхөн зарим нэг талыг цухас дурдъя.

Философийн ухаан манай оронд 1950-иад онд идэвхтэй хөгжихөд Д.Төмөр-Очир гуай голлон оролцож, чухал үүрэг гүйцэтгэсэнийг олж мэдэх баримт материал хангалттай байна. Тэдгээрийн зах зухаас заримыг нь дурдъя. Төмөр-Очир гуай 1950-1953 онд ЗХУКН-ын Төв Хорооны дэргэдэх Нийгмийн Ухааны Академийн аспирантурт суралцаж, философийн ухааны дэд эрдэмтний зэргийг 7 дугаар сард амжилттай хамгаалж ирээд 9 дүгээр сард Намын дээд сургуульд философийн багш, 1954 оноос 1955 оны 2 дугаар сар хүртэл тус сургуулийн Марксизм-ленинизмийн кафедрын эрхлэгч, 1955 оны 2 дугаар сараас МАХН-ын Төв Хорооны дэргэдэх Намын түүхийн институтын захирлаар ажиллахдаа намын түүх судлал дахь дутагдалыг арилгах, түүний олон чухал, ээдрээтэй асуудалд шинжлэх ухаанчаар, шинэ сэтгэлгээгээр хандаж шийдвэрлэх, намын товч түүхийн номыг боловсруулж бэлтгэхэд ихээхэн анхаарал тавьж, ахиц дэвшил гарахад нөлөөлжээ.

Төмөр-Очир гуай үүний зэрэгцээ 1953-1955 онд МАХН-ын Төв Хорооны онол-улс төрийн "Суртал нэвтрүүлэгч" сэтгүүлийн ерөнхий редактор байв. Эл сэтгүүл тухайн үедээ намын төдийгүй нийгмийн сэтгэлгээний хөгжил, шинэчлэлтэд чухал ач холбогдолтой байсныг түүнд нийтлэгдэж байсан өгүүлэл, материалуудаас олж мэдэж болно. Ер нь 1950-иад онд МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоо, намын их, бүгд хурлуудаас гаргасан удаа дараагийн олон тогтоолд чухалчлан зааж, холбогдох байгууллагад даалгаж байсны дагуу төвийн томоохон тогтмол сэтгүүл, гол сонинуудад эдийн засаг, нийгэм-улс төр, түүх, философи, ёс зүй, шашны янз бүрийн асуудлаар тухайн үеийн онолын сэтгэлгээний түвшинд бичигдсэн, сонирхолтой, шинэлэг өгүүлэл, лекцийн материал олноор нийтлэгдэж байжээ.

Төмөр-Очир гуай МАХН-ын 1954 оны 11 дүгээр сард хуралдсан XII их хуралд төлөөлөгчөөр оролцож (энэ үед 015763 тоот намын батлахтай байжээ) тус их хурлаар бүрэлдсэн МАХН-ын Төв Хорооны гишүүнээр сонгогдсон байна. Тэрбээр дээрхи ажил албыг хашиж, сонгуульт үүрэгтэй байхдаа тухайн үеийн намын онолын сэтгэлгээ, үзэл суртал, гэгээрлийн ажил, дээд боловсрол, нийгэм,

түүхийн шинжлэх ухаан, ялангуяа философийн ухаан манайд ямар байдалтай байгаа, ололт, дутагдал, шийдвэрлэвэл зохих зорилт, асуудал нь юунд байна вэ гэдгийг дурдсан салбаруудын дотор нь ажилласан хүний соргог нүдээр харж, шинэ, шүүмжлэлт сэтгэлгээтэй том эрдэмтэн мэргэжилтний өргөн цартай ухаанаар тунгаан бодож, олон удаагийн, янз бүрийн шатны хурал, уулзалт, ярилцлагад хэлсэн илэн далангуй үг яриа, бичиж нийтлүүлсэн өгүүлэл, тавьсан илтгэлдээ илэрхийлж байжээ (25).

Төмөр-Очир гуай 1958 оны 3 дугаар сард хуралдсан МАХН-ын XIII их хурлаас сонгогдсон Төв Хорооны Бүгд хурлаар Намын Төв Хорооны Улс Төрийн Товчооны орлогч гишүүн, Төв Хорооны нарийн бичгийн даргаар (үзэл суртал эрхэлсэн) сонгогджээ. Энэ нь намын онолын сэтгэлгээ, үзэл суртал, хүмүүжлийн ажлын дээшлэлт, ялангуяа философийн ухааны цаашдын хөгжилд ач тустай чухал үйл явдал болсон гэж үзэх хэд хэдэн үндэслэл байгаа юм. Тэдгээрээс зарим голыг нь дурдаж тэмдэглэе.

МАХН-ын XIII их хуралд тавьсан Төв Хорооны тайлан илтгэл, түүнд гаргасан тогтоолд намын үзэл суртал, онолын сэтгэлгээний зорилго нь Маркс-лениний онолыг эзэмшин, улс орныхоо нөхцөл байдалд бүтээлчээр хэрэглэх, догматизмтай тэмцэх явдал болохыг, тэдгээрт оршиж байгаа гол дутагдал бол үсэгчлэн цээжлэх, шинэ дэвшилт зүйлийг олж харж чадахгүй байх, олон түмний бүтээлч идэвх санаачилгыг хайхарч үзэхгүй байх, ажлын хуучин арга стилийг үхширтэл баримтлах, амьдралаас тасрах, ард түмний хөдөлгөөнөөс хоцрогдон сүүл барьж явах зэргээр илэрэн тодорч байгаа догматизм мөнийг хурц шүүмжлэн заасан байна (26,).

Их хурлын илтгэл, тогтоолыг Д.Төмөр-Очир гуай Намын Төв Хорооны гишүүн, бас философич эрдэмтний хувьд гар бие оролцож боловсруулан бэлтгэлцсэн нь мэдрэгдэж байгаа юм. Төмөр-Очир гуай намын их хурлын баримт бичигүүд дэх эдгээр шүүмжлэл, заалтын үзэл санаа, үндэслэлийг эл их хурал дээр хэлсэн дэлгэрэнгүй, философийн утга агуулгатай үгэндээ задлан дэлгэж: "...Социализм байгуулах зорилтыг жинхэнэ үйл ажилдаа хэрэгжүүлэн биелүүлэх ба хөдөлмөрчин олон түмэнд элбэг дэлбэг, жаргалант сайхан амьдрал зохиож өгөхийн тулд л бид онолыг судалж эзэмшдэг, зааж сурталчилдаг билээ. Нам үзэл суртлынхаа ажлыг гагцхүү олон түмний ухамсар мэдлэг, улс төрийн ба хөдөлмөрийн идэвх санаачилгыг байнга дээшлүүлэхийн ... төлөө зохиодог юм. ... Догматизм ба үг үсэгтэй зууралддаг явдалтай эрчимтэй тэмцэл хийхгүй, социализмыг байгуулахад амин чухал ач холбогдолтой практик асуудлыг шийдвэрлэхэд онолын агуу их хүчийг үр бүтээлтэйгээр ашиглаж сурахын төлөө чармайлт мэрийлт гаргахгүй байна. ... Манай намын онолын ажил, амьдрал практикийн шаардлагаас үлэмж ихээр хоцорч явна. ... Уншсан номдоо амьдралыг захируулж тайлбарлах, жинхэнэ бодит амьдралын бэрх зөрчилтэй процессыг анх социализм байгуулсан ЗХУ-ын туршлагаар боловсрогдсон бэлэн зэхээстэй томьёолол ухагдахуунд албан хүчээр чихэж тааруулахыг оролддог... Догматизм бол манай намын хөгжлийн одоогийн шатан дээр хамгийн гол аюул мөн. Манай боловсон хүчний гүйцэд торниж бойжоогүй байгаатай холбогдон гарсан догматизм

нь манай үйл ажиллагааны тал бүрд бугшиж, хор хохирол учруулж байна” гэх зэргээр шүүжлэн хэлжээ (27, 177-180).

МАХН-ын үүнээс өмнөх үеийн их, бүгд хурлын илтгэл, тогтоол шийдвэрүүдэд үзэл суртлын ажил, онолын сэтгэлгээний дутагдалын үндэс, голыг нь тэр бүр онон олж, нэгтгэн дүгнэсэн байдлаар илэрүүлэн гаргаж, зааж байсан гэж хэлэхэд хэцүү юм. Намын XIII их хурлын баримт бичигт үзэл суртлын талаар авч үзэж заасан зүйлүүдийг анхааран үзэхэд шинэлэг, шүүмжлэлт бөгөөд бүтээлч, ажил хэрэгч чанартай, тэдгээрт өмнөх хэдэн жилд Төмөр-Очир гуайн хэлж ярьсан, бичиж нийтлүүлсэн зүйлсийн үзэл санаа мэдэгдэхүйц байдлаар нөлөөлж туссаныг мэргэжлийн хүмүүс олж мэдрэх боломжтой юм. Ийм байдлыг МАХН-ын Төв Хорооны 1959 оны 3 дугаар сарын Бүгд хуралд Ю.Цэдэнбал даргын тавьсан “ЗХУКН-ын XXI их хурлын дүнгээс МАХН-ын үйл ажиллагаанд хийх дүгнэлт” гэсэн илтгэл болон түүнд гаргасан тогтоолоос мөн адил мэдэрч болохоор байна. Төмөр-Очирыг эл Бүгд хурлаас Намын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүнээр сонгожээ.

Төмөр-Очир гуай намын удирдлагад гарч ирээд өөрийн хариуцсан үзэл суртал, соёл гэгээрэл, хүмүүжлийн ажилд шинэлэг, бүтээлч, шүүмжлэлт сэтгэлгээгээр хандаж идэвхтэй ажиллахдаа нэг талаар, эдгээр салбаруудыг сайжруулж хөгжүүлэх онолын үзэл баримтлалын үндэс болсон, нөгөөтэйгүүр чухам өөрийн нь торгон мэргэжил бүхий философийн ухааныг улс орондоо хөгжүүлж дэвжүүлэх талаар ихээхэн анхаарч, намын үйл ажиллагаа, тогтоол шийдвэрийн түвшинд албан ёсоор болон нэлээд тохиолдолд өөрийн нэр хүндээр, эрдэмтэн, багш хүний хувиар монголын философчдад ач буянтай үйл хэргийг бүтээж байжээ. Энэ талаар баримт түшиж зарим зүйлийг өгүүлье.

МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1959 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн хурлаас гаргасан “Намын улс төр гэгээрлийн ажлын байдал ба цаашид тавих зорилт” гэсэн 25 тоот тогтоолд намын онолын сэтгэлгээний хөгжил, үзэл суртлын ажилд философийн гүйцэтгэх үүрэг, эзлэх байр суурийг дээшлүүлэх талаар чухал заалт оржээ. Тогтоолд суртал нэвтрүүлэгчид, улс төрийн боловсролын системийн нийт сонсогчдын марксист-ленинист онол, тэр дотор марксист философийн мэдлэгийг дээшлүүлэх, үүний тулд философийн сэдэвүүдээр мөчлөг лекц бэлтгэх, философийн сурах бичгийг 1959 оны 9 дүгээр сарын наана хэвлүүлэн гаргах, Намын Төв Хорооны Марксизм-ленинизмын тасгийг Суртал нэвтрүүлгийн тасаг болгох, түүнийг түүхч, эдийн засагч, философич мэргэжилтнээр дүүргэн 6 орон тоотой болгохыг заажээ (28).

Профессор Д.Содномгомбо багш нэг удаа бидэнд: “Төмөр-Очир гуай дарга байх үед гадаадад, ЗХУ-д мэргэжлийн философчдыг сургаж бэлтгэх талаар заасан Улс Төрийн Товчооны нэгэн тогтоол гаргуулсан. Би тэр үед Төв Хорооны суртлын хэлтэст зааварлагч байлаа. Төмөр-Очир гуай надад дэлгэрэнгүй, тодорхой зааж зөвлөсний дагуу тэр тогтоолын төслийг би бичиж бэлтгэсэн юм. Чи тэр тогтоолыг олж үз, чухал заалт байх ёстой, тухайн үед намын сэтгүүл, сонинд ч нийтлэгдсэн санагдаж байна” гэв. Тэр дагуу холбогдох ном зохиол, намын тогтоол шийдвэрийн эмхтгэл сэлтээс үзэж харсанд олдсонгүй, тэдгээрт нийтлэгдээгүй байна. Тэгээд МАХН-ын Баримтын төвд сууж, архивын материал үзэж байсан

завшаанаар эрж хайсанд тэр тогтоол Фонд – 4, данс - 24, хадгаламжийн нэгж – 199 –ээс гараад ирдэг байна шүү ! Манай философийн ухаантай нэн чухал учир холбогдолтой тэр тогтоол бол МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1959 оны 7 дугаар сарын 16 ны өдрийн хурлын 257 тоот дугаартай “Нам, улсын удирдах ажилтны марксист-ленинист онол, эдийн засгийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээний тухай” гэсэн дэлгэрэнгүй тогтоол юм. Тогтоолд тус оронд социализм байгуулах олон талтай, нарийн ээдрээтэй зорилтыг шийдвэрлэж буй нөхцөлд нам, улсын удирдах ажилтны марксист-ленинист онол, эдийн засгийн мэдлэг шаардлагын түвшинд хүрэхгүй байгаа, эл байдлыг цаашдаа өөрчилж тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх зайлашгүй шаардлагатай болохыг тэмдэглээд, хэрэгжүүлэх арга замыг тодорхой заажээ. Тогтоолын гуравдугаар заалтад “Манай оронд философийн шинжлэх ухааныг хөгжүүлэх ажил хэтэрхий хоцрогдож, онолын гүн зузаан бэлтгэлтэй философчид дутаж байгааг харгалзан зохих хүмүүсийг бэлтгэх зорилгоор Москвагийн Улсын Их Сургуулийн философийн салбар, Нийгмийн Ухааны Академид сурагч, аспирантуудыг оролцуулан явуулж байсугай. Энэ жил Москвагийн Улсын Их сургуулийн философийн салбарт 5 хүнийг явуулж сургасугай” гэж заажээ (29).

Тухайн үед мэдлэг, мэргэжлийн аль нэг тодорхой салбарыг хөгжүүлэх, түүгээр мэргэжилтэн бэлтгэх, тэр тусмаа философийн ухааны талаар намын дээд удирдлагаас тусгай тогтоол шийдвэр гаргах нь аль ч талаасаа зохимжгүй, бараг боломжгүй зүйл байсан гэж хэлбэл буруудахгүй болов уу. Тийм нөхцөлд Төмөр-Очир гуай өөрийнхөө араас өндөр боловсрол мэргэжилтэй, эрдмийн зэрэгтэй философчдыг ЗХУ-д бэлтгэх хэрэгтэй гэж бодож санасан санаа зорилтоо тэр үед зайлашгүй чухал болж тавигдаж байсан нам, улсын удирдах ажилтны марксист онол, эдийн засгийн мэдлэгийг дээшлүүлэх талаар намын дээд удирдлагаас гаргах тогтоол шийдвэрийн агуулга, үзэл санаанд нийцүүлэн шингээж, олон заалтуудын нь нэг болгож тун эвтэйхэн оруулж томъёолсон нь шинэ цагийн монголын философчдын багш нь болсон энэхүү эрхэм хүмүүн, нэрт философчын нарийн ухаан, философио гэсэн анхаарал, хүсэл зоригийн нэгэн тод илэрэл буй заа.

Улс Төрийн Товчооны дурьдсан тогтоол гарснаас 15 хоногийн дараа буюу 1959 оны 7 дугаар сарын 31 нд МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын зөвлөлгөөний “Москвагийн Их Сургуулийн философийн ангид хүмүүсийг явуулж сургах тухай” 477 тоот тогтоол гарч, түүнд “Дашдондогийн Цэрэн, Дашийн Содномгомбо, Сумъяагийн Пүрэв, Цэрэнпилийн Балхаажав, Рагчаагийн Нансал нарыг Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургуулийн философийн ангид явуулж сургахыг зөвшөөрсүгэй” гэж заажээ (30). Эдгээр хүмүүс сургуулиа амжилттай төгсөж ирээд манай философийн ухааны хөгжил, түүний эрдэм шинжилгээ, сургалт боловсролд өөр өөрийн үнтэй хувь нэмрийг оруулсан билээ.

Манай оронд XX зуун, түүний хоёрдугаар хагаст шинэ цагийн философийн ухаан үүсэж хөгжсөн асуудлыг судалсан эрдэмтэд ном бүтээлдээ философийн өндөр боловсрол, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэхэд чухал ач холбогдолтой болсон Улс Төрийн Товчооны дээр дурдсан тогтоолын талаар дурдаж бичээгүй, ер нь тийм тогтоол байдгийг тэр бүр мэддэггүй байна. Энэ нь Төмөр-Очир гуайг

намаас буруушааж, түүнийг талархан дэмжигч сэхээтнүүдийг мөн адил зэмлэж арга хэмжээ авсан хийгээд ийм нөхцөлд философийн ухааныг дэмжиж хөгжүүлэх талаар Төмөр-Очир гуайн хийж амжуулсан үйлс бүтээлийн тухай дурдаж бичих нь хэн хүний ажил амьдралд халгаатай байсантай холбоотой юм. Төмөр-Очир гуайтай хамт, удирдлага дор нь ажиллаж, тус дэмжлэгийг нь хүртэж байсан, түүнийг итгэл сэтгэлээрээ хүндэтгэж, талархаж явдаг хүмүүс ч тэрхүү хүндэтгэл, талархсан сэтгэлээ илэрхийлэхээс болгоомжилсоор ирснийг буруушаах аргагүй бөгөөд ойлгох хэрэгтэй юм.

Төмөр-Очир гуай Намын Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн, Төв Хорооны нарийн бичгийн даргын өндөр албыг хашиж байхдаа эл албан тушаалын нөлөө, хөшүүргийг философийн ухааны судалгаа, сургалт боловсрол, гадаад хэл дээрх холбогдох чухал ном зохиолоос орчуулж нийтлэх ач буянтай үйл хэрэгт боломжийн хэрээр чиглүүлэн ашиглаж байсны бас нэг баримт бүхий зүйлийг дурдъя. Манай орны их, дээд сургуулийн болон нам, залуучуудын эвлэлийн улс төрийн боловсролын системээр философийн мэдлэгийн үндэсийг үзэж суралцах, эзэмшихэд сайн сурах бичиг, гарын авлага ямагт чухал байсаар, бас үгүйлэгдсээр иржээ. Ийм үед зөвлөлтийн томоохон философчид хамтарч “Марксист философийн үндсүүд” гэсэн том хэмжээний сурах бичгийг зохиож 1958 онд хагас сая хувиар нийтлүүлсэн нь философийн мэргэжилтэн, уншигчидад таашагдаж төдөлгүй олдохгүй болжээ. Эл үед зөвлөлтийн философи Сталины тогтоож хэвшүүлсэн догматик загвараас алхам алхмаар чөлөөлөгдөн өөрчлөгдөж, шинэ эрэл хайгуул хийх болсон байлаа.

Төмөр-Очир гуай мэргэжлийн философич эрдэмтний хувиар эл номыг чухалчлан үзэж, монгол хэлэнд хөрвүүлэн нийтлүүлэх талаар анхаарал тавьсны үр дүнд МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын 1959 оны 11 дүгээр сарын 2 ны өдрийн зөвлөлгөөнөөс “Марксист философийн үндэсүүд” сурах бичгийг монгол хэл дээр орчуулж гаргах тухай 632 тоот тогтоол гарч түүнд номыг 1960 онд багтааж хэвлүүлэхийг Төв Хорооны Суртлын хэлтэст даалгажээ (31). Үүний дагуу Дашдорж, Цэрэнжав, Ц.Хасбаатар, Х.Гаадан, Д.Шаравжамц, Цэдэн, Бат-Очир, Ц.Балхаажав, Ж.Төмөрбаатар, Ц.Намсрай, Д.Сүрэнжав, Х.Бат, А.Минис, Даваадорж, Ж.Цэдэнжав, Сандаг нар номыг орчуулах ажилд шуурхайлан орж, бэлэн болсон 1600 орчим хуудсыг өрөлтөд өгөөд байжээ.

Гэтэл зөвлөлтийн зохиогчид нэгдүгээрт, эл ном эрэлт хэрэгцээ ихтэй, дахиж хэвлэх шаардлагатай болсон, хоёрдугаарт, 1959 оны 1-2 дугаар сард ЗХУКН-ын ээлжит бус XXI их хурал хуралдаж нийгмийн практик, намын онолын сэтгэлгээний талаар тэр үедээ шинэ чухал зорилт, асуудлыг дэвшүүлэн тавьсныг номын агуулга, үзэл санаанд тусгах шаардлагатай гэж үзэн, нэмэлт засвар хийж 1959 оны 10 дугаар сарын эцсээр хоёр дахь хэвлэлийг нь олон хувиар гаргажээ.

Номын хоёр дахь хэвлэлд түрүүчийнхээс нэлээд зүйл өөрчлөгдөж ном бүхэлдээ чанар чанцаатай болсон ажээ. Төмөр-Очир гуай болон холбогдох бусад хүмүүс үүнийг олж харж асуудал тавьсны үр дүнд МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын 1959 оны 12 дугаар сарын 30 ны өдрийн зөвлөлгөөнөөс “Марксист философийн үндэсүүд” гэдэг номын орчуулгыг дахин хянаж засварлах тухай 715 тоот тогтоол гарч, түүнд номын монгол орчуулгыг орос хэл дээрх хоёр

дахь хэвлэлтэй нь тулгаж нэмэлт орчуулга, засвар хийж хэвлүүлэх, анхны орчуулгын хэвлэлийн өрөлтнөөс үүссэн хохиролыг Намын Төв Хорооны хэвлэлийн зардлаас гаргахыг даалгасан байна (32).

Эл сурах бичиг орчуулгын редактор Ш.Цэвэгмид, Ж.Цэдэнжав, Ц.Хасбаатар нарын хянаж засварласнаар 44 хэвлэлийн хуудас бүхий том хэмжээгээр 1960 оны дундуур арван мянган хувь хэвлэгдэн гарч уншигчдын хүртээл болжээ. Нийт 19 бүлэгтэй эл номонд Марксист философийн үндэсийг философийн товч түүх, диалектик ба түүхийн материализмын үндсэн асуудлуудын дагуу системтэй, тухайн үеийн шинэлэг сэтгэлгээ, эрэл хайгуулын үүднээс гаргаж тавьсан байна. Сурах бичгийн хоёр дахь хэвлэл хожим ЗХУ-д 1980 –аад оны дунд үе хүртэл олон дахин хэвлэгдсэн марксист философийн гол сурах бичгийн үндэс болсон бөгөөд түүний монгол орчуулга 1960-аад онд манай их, дээд сургуулийн философийн багш, оюутан, философи үзэж суралцдаг нийт хүмүүсийн хэрэглэдэг чухал ном болж байжээ.

Бидний дээр сунжруулан өгүүлсэн зүйл бол тэр үед Намын Төв Хорооноос нийгэм-улс төр, философийн ном зохиолыг бэлтгэж нийтлүүлэх асуудалд үзэл суртлын үүднээс хянамгай хандахын хамт түүний чанар чансаанд өндөр шаардлага тавьдаг, зөвхөн ном зохиол төдийгүй ер нь аливаа ажил үүргийн гүйцэтгэлийг ихээхэн чухалчилж анхаардаг байсныг, түүнчлэн Төмөр-Очир дарга монголын философийн ухааныг хөгжүүлэх зорилт, асуудалд ямар хэмжээгээр сэтгэл гаргаж, бас анхаарал, шаардлага тавьж байсныг илэрхийлэх нэгэн баримт болно.

Төмөр-Очир гуай 1960 оны 7 дугаар сард албан тушаалаас бууж, 1962 оны 1 дүгээр сарын эцэс хүртэл бүтэн жил 6 сар ажил албагүй, байдал нь тодорхойгүй болсон үед түүний философийн амьдрал дахь нөлөө оролцоо нь мөн адил бүдгэрсэн бололтой юм. Тэгэхдээ тэрбээр энэ хугацаанд Намын Төв Хорооны гишүүн хэвээр байв. Түүнийг Төв Хорооны Улс Төрийн Товчооны гишүүн, Төв хорооны нарийн бичгийн даргаар дахиж сонгосон МАХН-ын Төв Хорооны 1962 оны 1 дүгээр сарын Бүгд хурал дээр тэрбээр дэлгэрэнгүй үг хэлж, түүндээ манай орны улс төрийн түүхэн замнал, хэлмэгдүүлэлт, Чойбалсанг тахин шүтэж байсан асуудал, Цэдэнбал болон намын бусад удирдах хүмүүсийн ажил байдал, намын улс төр-зохион байгуулалт, үзэл суртлын үйл ажиллагааны дутагдалыг хурц шүүмжлэн, бодож санасан, дүгнэж үнэлсэн зүйлээ илэн далангүй уудлан гаргасан байна. Эл үгийг Төмөр-Очир гуайн нийгэм-улс төрийн болон түүхийн талаархи үзэл бодол, философийн санаа бодролыг судлахад төдийгүй ер нь 1960-аад оны эхэн үеийн МАХН-ын дотоод амьдрал, удирдах бүрэлдэхүүний байдал, байр суурь зэрэг асуудлыг судлахад нэгэн чухал баримт болгож авч үзүүштэй юм.

XX зууны Монгол Улсын гадаад дотоод түүхэн нөхцөл байдал, цаг үеийн эрхээр МАХН 1990 он хүртэл ганцаараа төр барьж, монголын нийгмийг удирдан жолоодож, түүний амьдралын аливаа асуудал, зорилтыг тодорхойлон шийдвэрлэж байсантай нягт уялдаж манай философийн ухааны үүсэл, хөгжил, төлөв байдал нь эл намын улс төрийн бодлого, үзэл суртлын үйл ажиллагаагаар тодорхойлогдон нөхцөлдөж байжээ. Тиймээс МАХН-ын тогтоол шийдвэр, баримт бичгийн сан хөмрөгт манай орны философийн ухааны түүхтэй холбоотой олон

чухал, сонирхолтой мэдээ баримт агуулагдаж байгаа бөгөөд түүнийг эрдэмтэд судлан шинжилсээр иржээ. Одоо манай философич эрдэмтэдийн өмнө урьд нь хийгдсэн судалгааны үргэлжлэл, тэгэхдээ нэг ёсны төгсгөлийн хэсэг болгож XX зууны монголын философийн сэтгэлгээний түүхэн тоймыг судлан гаргаж дорвитой бүтээл туурвих зорилт тавигдаж байгаа билээ. Түүнийг гүйцэтгэхдээ монголын шинэ цагийн философийн сэтгэлгээний түүхэн замнал, асуудлууд нь МАХН-ын тогтоол, шийдвэр, баримт бичигт тусаж тэмдэглэгдсэнийг чухал эх сурвалж болгож, өмнөх үеийнхээс илүү нягт нямбай шүүн үзэж, шинэлэгээр судлан шинжлэх шаардлагатай болох нь ажиглагдаж байна. Энэ нь МАХН-ын үзэл суртлын ажлын түүхийг эргэн санагалзаж авч үзсэн хэрэг огт болохгүй гэдгийг философчид бүрнээ ойлгоно.

Одоогоос хагас зуун жилийн өмнөх 1950-иад оны үеийн монголын нийгмийн оюун санааны амьдрал, түүний дотор философийн ухааны төлөвшил, хөгжлийн дээр дурдсан шинж, ололт ба дутагдал, бэрхшээл нь чухам тэр үеийн нөхцөл, цаг үеийн хүрээн дэх түүхэн тодорхой чанартай үзэгдэлүүд байсан бөгөөд тиймээс тэдгээрийг авч үзэж судлах, үнэлж дүгнэхдээ мөн адил түүхэн тодорхой хандах, өөрөөр хэлбэл өнөөгийн өндөрлөгөөс нэг талаар голж үгүйсгэх, эсвэл дан магтаж зохиомолоор эдүгээжүүлэхгүй байх ёстой гэдгийг номын эл зүйлийн төгсгөл болгож тэмдэглэе.

Резюме

Статья посвящена рассмотрению общего состояния политического сознания монгольского общества в 1950-х годах. Данный период в политической истории Монголии отличается весьма насыщенными, противоречивыми процессами и событиями в жизни монгольского общества. Под непосредственным влиянием позитивных изменений в жизни Советского общества после смерти Сталина, в политической, особенно в духовной жизни монгольского общества, в том числе и в политическом сознании интеллигенции происходили заметные изменения. Оны выражались в критическом видении и новым и осмыслении политической истории общества в первой половине XX века, реального состояния и уровня развития страны в данный период, его дальнейшей перспективы. Одним из главных, активных инициаторов этих перемен явился видный монгольский ученый – философ, партийный деятель Д.Тумур-Очир. Он заняв высокий пост секретаря ЦК МНРП, являясь членом Политбюро ЦК, сделал много нового и полезного для обновления политической, духовной жизни монгольского общества. В статье особое внимание уделено рассмотрению роли Д.Тумур-Очира в становлении и развитии философской науки в стране, в подготовке квалифицированных философов для вузов и научных учреждений. Статья написана на основе изучения архивных материалов и других достоверных документов.

Ишлэл зүүлт

О культе личности и его последствиях. Доклад Первого секретаря ЦК КПСС тов. Хрущева Н.С. 25 февраля 1956 года. – Известия ЦК КПСС.- 1989. № 3. стр. 128-170

1. МАХН-ын Төв Хорооны 1956 оны 4 дүгээр сарын IV Бүгд Хурлын тогтоол.- МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. 1940-1960 он. Хоёрдугаар дэвтэр. УХХЭХ, УБ., 1967
2. МАХН-ын Төв Хорооны VI Бүгд хурлын тогтоол. “ЗХУКН-ын Төв Хорооны 1957 оны 6 дугаар сарын Бүгд хурлын шийдвэрийн тухай”. – МАХН-ын Төв Хорооны Бүгд хурлуудын тогтоол шийдвэр. III хэсэг. 1957-1962. УХХЭХ, УБ., 1963, 61-62 дахь тал
 - Нөхөр Ю.Цэдэнбалын илтгэлд МАХН-ын Төв Хорооны III Бүгд хурлаас гаргасан тогтоол. “ЗХУКН-ын XXI их хурлын дүнгээс МАХН-ын үйл ажиллагаанд хийх дүгнэлтийн тухай”. – МАХН-ын Төв Хорооны Бүгд хурлуудын тогтоол шийдвэр. III хэсэг. 126-136 дахь талд.
3. МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны хурлын тогтоол. 1956.12.5, № 413. – “Манай намын бодлогод харш үзэл санаа, үг, өгүүлэл гарч байгаа тухай”. - Үндэсний Төв Архив. МАХН-ын Баримтын Төв. Ф-33, Д-1, ХН-47, 56 дахь талд
4. Тэдгээрийн дотроос дараах гол бүтээлүүдийг дурдья. Үүнд:
 - БНМАУ-ын соёлын түүх (1921-1940). Тэргүүн боть. Ерөнхий редактор, академич Ш.Нацагдорж. УХГ, УБ.,1981
 - БНМАУ-ын соёлын түүх (1941-1960) Дэд боть. Ерөнхий редактор, академич Ш.Нацагдорж. УХГ, УБ.,1986
 - Жүгдэр Ч. Шинэ хүнийг хүмүүжүүлэх асуудалд. МХЗЭ-ийн Төв хорооны хэвлэл. УБ., 1968
 - Дэлэг Г. Монгол хэвлэл (1940-1970). Редактор Г.Очирбат. УХГ, УБ.,1971
 - Чунагсүрэн Ж.БНМАУ-ын залуучуудад ертөнцийг үзэх социалист үзэл бүрэлдсэн нь. Редактор Г.Лувсанцэрэн. УХГ.УБ.,1976
 - Дашжамц Д.БНМАУ дахь марксист сэтгэлгээний хөгжилт (1940-1960 он). Редактор Г.Лувсанцэрэн. ШУАХ, УБ.,1978
 - Даш-Ёндон Б. Хөдөлмөрчдийн социалист ухамсарт чанарт төлөвших диалектик. УХГ, УБ.,1980
 - Роозон Ж. МАХН-ын улс төрийн боловсролын систем: үүсэл хөгжил, цаашдын төлөв. УХГ, УБ.,1984
 - Хөдөлмөрчдийн шашингүйн хүмүүжлийн өнөөгийн асуудал. Редактор С.Пүрэвжав, Т.Содномдаргиа, Р.Вандангомбо. ШУАХ, УБ.,1985
 - БНМАУ дахь үзэл суртлын тэмцлийн түүхэн туршлагаас (Хамтын бүтээл). Редактор Д.Дашжамц, Г.Лувсанцэрэн. ШУАХ, УБ., 1985
 - Түмэндэлгэр Ч. Проблемы формирования социалистического сознания масс в МНР. Редактор Т.Баасансүрэн. УХГ, УБ., 1988

- Самбуу Б. БНМАУ –ын ардын боловсролын систем: намын бодлого түүний хэрэгжилт. Редактор К.Зардыхан, Х.Дүгэр. УХГ, УБ., 1989
- Даваасамбуу П. БНМАУ-ын соёл гэгээрлийн ажлын түүхэн замнал. Редактор Т.Содномдаржаа. УХГ, УБ., 1990
- 5. МАХН-ын Х их хурал. Дэлгэрэнгүй тайлан. УХГ, УБ., 1970
- 6. Мөн зохиол
- 7. Мөн зохиол
- 8. МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны хурлын тогтоол. 1962.6.3, № 208. – “Бичиг үсэг бага мэддэг ба бага сургуулийн боловсролгүй намын гишүүдэд үзүүлэх туслалцааг өргөтгөн сайжруулах тухай”. - Үндэсний Төв Архив. МАХН-ын Баримтын Төв. Ф-4, Д-26, ХН-26, 194 дэх талд
- 9. Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн түүх. Зохиогч: Ч. Сэрээтэр, Х.Цэдэв, Б.Чадраа. Редактор: А.Очир, Б. Чадраа. УБ., 2002
- 10. “Шинжлэх ухаан, дээд боловсролын Хүрээлэнгийн ажлын байдал ба шинжлэх ухааныг хөгжүүлэх талаар цаашид тавих зорилтууд”. МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчоонд илтгэх илтгэл. Илтгэгч: Д.Цэвэгмид.- Үндэсний Төв Архив. МАХН-ын Баримтын Төв. Ф-1, Д-26, ХН-263, 14 дэх тал
- 11. Энэ талаар дараах бүтээлүүдээс дэлгэрэнгүй үзэж болно. Үүнд:
 - Дашжамц Д.Марксизм-ленинизм монголд дэлгэрэн хэрэгжсэн нь. УБ., 1974, 210-213 дахь талд
 - Чунагсүрэн Ж. БНМАУ-ын залуучуудад ертөнцийг үзэх социалист үзэл бүрэлдсэн нь. УБ., 1976
 - Дашжамц Д. БНМАУ дахь марксист сэтгэлгээний хөгжилт. УБ., 1978
 - Роозон Ж. МАХН-ын улс төрийн боловсролын систем: үүсэл хөгжил, цаашдын төлөв. УБ., 1984
- 12. Роозон Ж. Дурдсан зохиол
- 13. МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны тавдугаар хурлын тогтоол. 1947. 2.1. “Улсын Их сургуулийн хичээл сурлагын явцыг шалгасан дүнгийн тухай”. – МАХН-ын тогтоол шийдвэр баримт бичгүүд. Гуравдугаар боть. 1940-1947. Эмхтгэгч Б.Монц, Ө.Энхтүвшин. Ерөнхий редактор Ц.Намсрай, Б.Лхамсүрэн. УБ., УХГ, 1985
- 14. Дашжамц Д. БНМАУ дахь марксист сэтгэлгээний хөгжилт. УБ., 1978
- 15. Дашжамц Д. Академич, гүн ухаантан, нийгмийн нэрт зүтгэлтэн Д.Төмөр-Очирын намтар (1921-1985). Редактор Г.Чулуунбаатар. УБ., “Жинст Харанга” ХХК, 2001
- 16. Нийгмийн шинжлэх ухааны сургууль (Түүх, баримтын эмхтгэл). Эрхэлсэн: З.Баасанжав, Ш.Содном. Хянан тохиолдуулсан Р.Дарьхүү, Г.Эрдэнэбаяр. УБ., “Нью Полиграф” ХХК, 2007
- 17. Нийгмийн шинжлэх ухааны сургууль (Түүх, баримтын эмхтгэл). УБ., 2007, 5 дахь талд
 - МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны “Улсын Их сургуулийн хичээл сурлагын явцыг шалгасан дүнгийн тухай” тогтоолын 13 дахь

- заалтад оюутны улсын шалгалтанд оролцох хичээлийн тоонд философийг оруулсан байна.
18. Роозон Ж. МАХН-ын улс төрийн боловсролын систем: үүсэл хөгжил, цаашдын төлөв. 50 дахь талд
 19. Холбогдох баримт бичгээс үзэхэд 1950-иад онд Д.Төмөр-Очир, Жовдоогийн Төмөрбаатар, Ч.Жүгдэр, Ц.Балхаажав, Б.Дамдинсүрэн, С.Норовсамбуу, А.Сунгубай, Ү.Нямдорж, Г.Лувсанцэрэн зэрэг философийн багш нар төрөн гарчээ.
 20. Энэ талаар: Д.Дашжамц. БНМАУ-ын марксист сэтгэлгээний хөгжилт. УБ., 1978, 106-108, 115-118 дахь талд үзнэ үү.
 21. Д.Төмөр-Очир гуайн дараа Б.Балдоо 1955 онд, Ч.Жүгдэр 1958 онд, С.Норовсамбуу, Ж.Төмөрбаатар, Д.Лхамжав нар 1959 онд аспирантурт суралцахаар гадаадад оджээ.
 22. Монголын философчдын хамтран боловсруулж бэлтгэсэн анхны сурах бичиг бол 1971 онд нийтлэгдсэн “Марксист-ленинист философи. Диалектик материализм”. АБЯ-ны хэвлэл. УБ., 1971 (Зохиогчид: С.Норовсамбуу, Ч.Жүгдэр, Цо.Намсрай, Ж.Цэдэнжав, Э.Базаржав, Д.Содномгомбо, Р.Нансал, Х.Батаа, Су. Пүрэв. Редакцийн коллеги: Э.Базаржав, Цо. Намсрай, С.Норовсамбуу). Үүний дараа 1973 онд эл сурах бичгийн үргэлжлэл болж “Марксист-ленинист философи. Түүхийн материализм”. АБЯ-ны хэвлэл. УБ., 1973 (Зохиогчид: С.Норовсамбуу, Ц.Балхаажав, Р.Нансал, Цо.Намсрай, Д.Содномгомбо, Ж.Цэдэнжав, Ц.Нямдорж, Х.Батаа, Д.Дагвадорж, Ж.Бямбадорж, Э.Базаржав, Су.Пүрэв. Редакцийн коллеги: Э.Базаржав, Цо.Намсрай, С.Норовсамбуу).
 23. Диалектик материализм. Академич Г.Ф.Александровын редакцийн дор. УБ., 1955 (Орос хэлнээс орчуулсан)
 - Түүхийн материализм. Академич Ф.В. Константиновын редакцийн дор. УБ., 1956 (Орос хэлнээс орчуулсан)
 24. “Ард түмнийхээ тусын тулд...” буюу Дарамын Төмөр-Очир. Өгүүлэл, тэмдэглэл, илтгэл, хэлсэн үг, асуултын хариулт, хувийн өргөдөл. 1953-1965 (Судалгаанд зориулж товчлон нийтлэв). Дэд дэвтэр. УБ., “Сод пресс” ХХК, 2001
 25. МАХН-ын XIII их хурал (Дэлгэрэнгүй тайлан). УБ., УХГ. 1958
 26. “Ард түмнийхээ тусын тулд...” буюу Дарамын Төмөр-Очир. Өгүүлэл, тэмдэглэл...
 27. МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны хурлын тогтоол. 1959.1.20. №25. - “Намын улс төр, гэгээрлийн ажлын байдал ба цаашид тавих зорилт”.
 - Үндэсний Төв Архив. МАХН-ын Баримтын Төв. Ф-4, Д-24, ХН-198, 34 дэх хуудас
 28. МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны хурлын тогтоол. 1959.7.16. №257. “Нам, улсын удирдах ажилтны марксист-ленинист онол, эдийн засгийн мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээний тухай”. - Үндэсний Төв Архив. МАХН-ын Баримтын Төв. Ф-4, Д-24, ХН-199, 70 дахь талд

29. МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын зөвлөлгөөний тогтоол. 1959.7.31. № 477. “Москвагийн Их сургуулийн философийн ангид хүмүүсийг явуулж сургах тухай”. - Үндэсний Төв Архив. МАХН-ын Баримтын төв. Ф-1, Д-36, ХН-89, 81 дэх талд
30. МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын зөвлөлгөөний тогтоол. 1959.11.02. № 632. “Марксист философийн үндэсүүд” сурах бичгийг монгол хэл дээр орчуулж гаргах тухай. - Үндэсний Төв Архив. МАХН-ын Баримтын төв. Ф-1, Д-36, ХН-90, 61 дэх талд
31. МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарын зөвлөлгөөний тогтоол. 1959.12.30. № 715. “Марксист философийн үндэсүүд” гэдэг номын орчуулгыг дахин хянан засварлах тухай. - Үндэсний Төв Архив. МАХН-ын Баримтын төв. Ф-1, Д-36, ХН-90, 148-149 дэх талд